

Америкийн тогтмол сэтгүүлүүд-нийгмийн мэдээллийн чухал хэрэгсэл

*М.Хурметхан. Дэд доктор,
“Америк: судалгаа мэдээлэл”
сэтгүүлийн нарийн бичгийн дарга*

АНУ бол сонин, радио нэвтрүүлэг, зурагт радиогийн асар их хүчирхэг бүтэц бүрэлдэж хөгжсөн орон билээ.

Америкийн бүрэн хэмжээний сонинууд бол хүмүүст хэрэгцээт мэдээллээ олж авахад хамгийн ихээр тусалдаг юм. Эдгээр сонин тоонд “Нью-Йорк Таймс”, Нью-Йорк геральд трибюн”, Нью-Йорк дейли Ньюс”, “Вашингтон пост” зэрэг олон сонинг нэрлэж болох байна.

1986 оны байдлаар АНУ-ын 6516 хотод (өдөр тутмын, Ням гаригийн, долоо хоногийн гэх мэт) нийт 9,144 сонин гарч байлаа. Өдөр тутмын ихэнхи сонингууд баярын өдрүүдэд ч гэсэн тасралтгүй хэвлэгдэнэ. Дэлхийн 34 янзын хэлээр гардаг гадаад хэлний 85 сонинг оролцуулан АНУ-д хоногт 63 сая гаруй ширхэг сонин худалдагдана. Ням гаригийн 762 сонин тогтмол сонинуудыг бодоход илүү олон хувиар хэвлэгддэг ажээ. Хамгийн олон хуудсаар хэвлэгддэг Ням гаригийн сонинд “Нью-Йорк таймс” тооцогдоно. Ер нь ням гаригийн сонингуудын хэвлэх хувь нь дунджаар 57 сая орчим болно. Эдгээрээс гадна долоо хоногоор, долоо хоногт хоёр удаа эсвэл сард нэг удаа гардаг. 7.000 гаруй сонин бас байдаг байна.

Америкт өдөр тутмын сонингууд бол чанарыг илүү эрхэмлэдэг байна. Хамгийн олон хэвлэгддэг хорин сонингоос хоёр, гурав нь гэмт хэрэг, эр эмийн явдал, үймээн шуугиан бичдэг ажээ. Сүрхий нэр хүндтэй сонин бас байдаг бөгөөд тийм сонин нэгэнд “Уэлл стрит журнал” тооцогддог байна.

Америкт зарим сонинг хот, хөдөөгүй хүмүүс худалдан авч уншдаг боловч нийт үндсэнтгээрээ уншдаг “АНУ: өнөөдөр” хэмээх сонин гарах оролдлого хийж байжээ. Гэтэл уншигчид нь муж улс, хот, орон нутгийн мэдээ, улс төрийн байдал сэлтийг илүү их сонирхон уншдаг нь тодорхой болсон

байна. Нөгөө талаар “Нью-Йорк Таймс”, “Вашингтон пост”, “Лос-Анжелес Таймс” сонинууд бол улс үндэстний хэмжээний мэдээлэл пуглуулан АНУ-д болон хилийн чанадад худалдан мэдээллээр хангадаг байна. Тэдгээр сонинд гарсан мэдээг бусад сонинд иш татан мэдээлж, зохих төлбөр төлөх ёстой байдаг боловч зайлсхийх явдал гардаг байна.

Америкийн сонин хэвлэл нь дэлхий дахинд ихээхэн нэр хүндтэй байдаг нь үнэн бодит мэдээлэл өгдөгтэй холбоотой байна. Тэгээд ч АНУ-ын олон сонин, сэтгүүлийг Америктаа болон хилийн чанадад ихээр захиалан уншдаг ажээ. Тийм сонингуудад “Христиан Сайнес Монитори”, “Балтимор Сан”, “Милуоки журнал” зэрэг ордог байна. Америкийн томоохон сонин тусгай сурвалжлагчид, тоймчдын мэдээ, сурвалжлага бусад жижиг сонинд ч хэвлэгдэнэ. Ингэснээр жижиг хотын оршин суугчид нийт үндэсний болон олон улсын амьдралтай танилцуулах боломжтой болдог байна. Сонингууд хүмүүст сонирхолтой, ашигтай мэдээлэл хүргэхэд голлон анхаардаг нь мэдээж. Тэгэд ч сонингууд өөр хоорондоо хоршиж ажилладаг байна.

АНУ-д өдөр тутмын олон сая хувиар тараадаг сонингууд гэвэл “Уолл Стрит журнал”, “Нью-Йорк Дейли Ньюс”, “ЮСА Тудэй”, “Лос-Анжелес Таймс”, Нью-Йорк таймс”, “Вашингтон Пост”, “Чикаго Трибюн”, “Нью-Йорк Пост”, “Детроит Ньюс”, “Детроит Фри Пресс”, “Чикаго Сан Таймс”, “Сан Франциско Хроникль”, “Бостон Глобе” зэрэг болно. АНУ-ын хамгийн их хувиар хэвлэгддэг өдөр тутмын 25 сонин талаархи мэдээллийг хавсаргав. (The World Almanac and Book of Facts. 1995. P.305. хавсралт №1).

Цахилгаан мэдээний агентлаг. Америкийн хэвлэлийг мэдээллээр хангадаг цахилгаан мэдээний хоёр гол агентлаг бол Ассошейтед Пресс (АП) болон Юнайтед Пресс Интернейшнел (ЮПИ) хоёр болно. Энэ хоёр агентлаг олон улсын хэмжээнд хамгийн том цахилгаан мэдээний агентлагт тооцогдоно. АП агентлагийн сурвалжлагчид, зурагчид дотоодын 122, гадаадын 65 мэдээлэх товчоонд ажилладаг бол ЮПИ-ийнх дотоодын 92;90 гаруй улсыг хамарсан гадаадын 81 товчоотой байдаг байна. Тэдгээрээс мэдээ, гэрэл зураг хүлээн

авах сонин сэтгүүл, радио, телевиз, агентлагууд зэрэг олон тооны захиалагчид байдаг ажээ. АП, ЮПИ-гээс шууд болон тойруу замаар хоёр миллиард хүн мэдээллийнхээ ихэнхи хувийг олж авдаг гэж үздэг ажээ.

Америкийн сонинны өвөрмөц нэгэн шинж бол сонин мэдээний тухай дүгнэлт, мэдээ хоёрыг ялган салгаж байхыг анхааран үздэг явдал байна. Ялангуяа үнэн, зөв, туйлшраагүй мэдээ нийтлэх нь уншигчдын эрэлт хэрэгцээнд илүү нийцдэг байна. Үйл явдлыг үнэн бодитой мэдээлдэг байр сууриа баттай хамгаалах хатуу журам АП, ЮПИ хоёрын аль алинд байдаг ажээ.

АНУ-д Засгийн газрын мэдээллийн цахилгаан мэдээний агентлаг, сонин байдаггүйгээс гадна хэвлэлд төрийн хяналт тавих алба байхгүй юм. Харин “Мэдээллийн эрх чөлөөний акт”-аар бол сонин сурвалжлагчдыг оролцуулан хэн ч гэсэн мэдээлэл олох эрх зөвшөөрөгдсөн байх юм. Америкийн хэвлэл нь өөрийн зорьсон эрүүл ардчилалд зайлшгүй шаардагдах нийгмийн үйлчилгээний хүрээний үүрэг гүйцэтгэдэг ажээ.

Сэтгүүд. АНУ-д тогтмол хэвлэгддэг сэтгүүл 11.000 гаруй байна. Тэдгээрийн 4.000 гаруй нь сар тутам, 1.300 гаруй нь долоо хоног тутам гарна. Сэтгүүлүүд сэдвийн хувьд асар их өргөн хүрээтэй асуудал, түүний дотор шинжлэх ухааныг ихээр анхаардаг байна. Олон улсын чанартай сэтгүүлүүдийг гадаад хэлээр орчуулан гаргадаг бөгөөд зарим оронд “салбар” хэвлэлтэй байдаг ажээ. Олон улсын чанартай тийм сэтгүүлийн тоонд “Үндэсний газар зүй”, “Уншигчийн лавлах”, “Цаг үе”, “Долоо хоногийн мэдээ”, “Судлаач Америк” зэрэг орно. Долоо хоног тутмын сэтгүүлээс “Тайм”, “Ньюс Уник”, “Ю.С.Ньюс-Уорлд Репорт” зэрэг нийт үндэсний хэмжээгээр үйлчилдэг сэтгүүлүүд байна. “Тайм” олон улсын нөлөө бүхий хэвлэл ажээ. Тус сэтгүүлд дэлхийн олон орон, бүс нутгийн зориулалтаар гаргадаг нь хүмүүсийн сонирхолыг ихээр татдаг байна. Нөгөө талаар мэргэжлийн чиглэлийн олон тооны сэтгүүл хэвлэгдэнэ. АНУ-ын сэтгүүлүүд нь мэдээлэл сайтай, чамбай хэвлэгдэх тул зах зээлээр дутдаггүй ажээ. Тухайлбал “Нейшнл Жеографик” сэтгүүл дунджаар 10 сая илүү хувь

хэвлэгддэг бол 3 сая 2 сая хувиар зарагддаг сэтгүүл АНУ-д 60 орчим, дугаар бүр нь хагас саяас дээш хувиар зарагддаг сэтгүүл мөн тэр орчим ажээ. Өгүүллийн төгсгөлд 1993-1994 оны байдлаархи тус орны гүйлгээтэй 25 сэтгүүлийн нэрс, түгээлтийн хувийг үзүүлсэн хүснэгт (№2)-ийг хавсаргалаа.

Радио, телевиз. АНУ-д 1920 оноос радио станц ажиллаж эхэлсэн байна. АНУ-д хувийн радио станц, арилжааны радио станц, олон түмний сургалтын радио станц гэх мэт төрөл байна. Тэрчилэн олон зуун хувийн телевизийн станц ажиллана. Тэд өөр өөрсдийнхөө хөтөлбөрөө боловсруулан нэвтрүүлэг хийдэг ажээ. Радио станц, телевизийн станцууд арилжааны, арилжааны бус байна. Арилжааны бус нь ашиг орлого хөөцөлдөхгүй, зарлал сурталчилгаа явуулдаггүй байна.

АНУ-ын радиогийн 10.000 шахам станц, 1200 илүү телевизийн станц нэвтрүүлгийн хэмжээ, хэлбэрийн хувьд харилцан адилгүй ажээ. Нөгөө талаар АНУ-ын бүх, радио, телевизийн станцууд хувийн ба улсын, боловсролын ба арилжааны, том, жижиг, аль нь ч гэсэн Харилцаа холбооны улсын хорооноос зөвшөөрөл авдаг ажээ. Гэхдээ нэвтрүүлэг хүлээн авах, радио, телевизийн хүлээн авах хэрэгсэл эзэмших, агаараар дамжиж нэвтэрч буй юуг ч гэсэн хүлээн авахад ямар нэгэн үнэ, төлбөр, татвар, зөвшөөрөл хэрэггүй байдаг ажээ. Дээрх өгүүлсэн цөөхөн зүйлээс ажиглахад америкийн иргэд өргөн хүрээтэй, чанартай, үнэн зөв мэдээллийг хурдан шуурхай, чөлөөтэй хүлээн авах бүхий л боломжоор хангагдсан нь харагдана.

Хавсралт №1

Newspaper

Circulation

1. Wall Street Journal (New York, NY)	(m)	1,818,562
2. USA Today (Arlington, VA)	(m)	1,494,929
3. Times (New York, NY)	(m)	1,089,690
4. Times (Los Angeles, CA)	(m)	1,089,690
5. Post (Washington)	(m)	813,908
6. Daily News (New York, NY)	(m)	764,070
7. Newsday (Long Island, New York, NY)	(all day)	747,890
8. Tribune (Chicago, IL)	(m)	690,842
9. Free Press (Detroit, MI)	(m)	556,116
10. Chronicle (San Francisco, CA)	(m)	544,253
11. Globe (Boston, MA)	(m)	507,647
12. Morning News (Dallas, TX)	(m)	493,837
13. Inquirer (Philadelphia, PA)	(m)	486,586
14. Star-Ledger (Newark)	(m)	473,553
15. Chronicle (Houston)	(all day)	413,448
16. Star Tribune (Minneapolis, MN)	(m)	410,754
17. Herald (Miami, FL)	(m)	403,555
18. Plain Dealer (Cleveland, OH)	(m)	395,791
19. Post (New York, NY)	(m)	394,431
20. Union-Tribune (San Diego, CA)	(all day)	383,827
21. News (Detroit, MI)	(m)	366,988
22. Times (St. Petersburg, FL)	(m)	356,909
23. Sun-Times (Chicago, IL)	(m)	353,793
24. Arizona Republic (Phoenix, AZ)	(m)	347,839
25. Register (Orange County, CA)	(m)	343,906

№2

Magazine

1. Reader's Digest	16,261,968
2. TV Guide.....	14,122,915
3. The Conde Nast Select.....	11,039,917
4. National Geographic.....	9,390,787
5. Better Homes & Gardens.....	7,600,960

6. Good Housekeeping.....	5,162,597
7. Ladies' Home Journal.....	5,153,565
8. Family Circle.....	5,114,030
9. Woman's Day.....	4,858,625
10. McCall's.....	4,605,441
11. Time.....	4,103,772
12. People.....	3,446,569
13. National Enquirer.....	3,403,330
14. Playboy.....	3,402,617
15. AAA World.....	3,400,807
16. Sports illustrated.....	3,356,729
17. Redbook.....	3,345,451
18. Prevention.....	3,220,763
19. Newsweek.....	3,156,192
20. American Legion.....	3,004,913
21. Star.....	2,957,915
22. Cosmopolitan.....	2,627,491
23. Southern Living.....	2,368,578
24. Glamour.....	2,304,769
25. US news and World Report	2,281,369